Хуулийн хүрээнд нийтийн эрх ашгийг дээдлэн хариуцлагыг чухалчилж, удирдлагын нэгдмэл, уян хатан тогтолцоог бүрдүүлэн сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн дэд бүтцийг бий болгож, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлснээр үйл ажиллагаандаа чанарыг эрхэмлэн, үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг ямагт өндөр түвшинд байлгах зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тус сургууль дотоод хэргийн салбарын болон онцгой байдлын албаны хүний нөөцийг мэргэжлийн боловсрол, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтаар бэлтгэхийн зэрэгцээ удирдах бүрэлдэхүүний давтан, мэргэшүүлэх, албан тушаалын болон стратегийн дамжааны сургалтыг зохион байгуулдаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Дотоод хэргийн их сургууль Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Дээд боловсролын тухай, Төрийн албаны тухай, Хилийн тухай, Хөдөлмөрийн тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал: төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/180 дугаар тушаалаар салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль тайлант оны санхүүгийн тайланг Захирлын 2016 оны А/196 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн дагуу бэлтгэсэн байна. Тус бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын өөрчлөлтийг тухай бүр тусгаагүйгээс шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/180 дугаар тушаалаар салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан тул тус сургууль Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ өөрчлөлт оруулж амжаагүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130,393.3 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	446,950.2	3,668.7	(443,281.5)
Авлага	17,682.4	786,736.4	769,054.0
Урьдчилгаа	211,482.8	512,543.1	301,060.3
Бараа материал	4,129,294.4	4,296,001.9	166,707.5
Үндсэн хөрөнгө	94,314,561.3	93,390,627.7	(923,933.6)
Нийт хөрөнгө	99,119,971.1	98,989,577.8	(130,393.3)
Өр төлбөр	3,668.7	37,269.3	33,600.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	99,116,302.4	98,952,308.5	(163,993.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	99,119,971.1	98,989,577.8	(130,393.3)

Эх сурвалж: Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дараах дансны үлдэгдэлд материаллаг хэмжээний өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,668.7 мянган төгрөг болж, тайлант онд ахмадын сангаас 307,858.1 мянган төгрөгийг зарцуулж, 135,423.4 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэнтэй холбоогоор 443,281.5 мянган төгрөгөөр буурсан;
- Авлага дансны үлдэгдэл 786,736.4 мянган төгрөг болж, тайлант хугацаанд Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн 754,054.0 мянган төгрөгийн, ГХУСАЗЗАА-наас авах гэрээт ажлын хөлсний 15,000.0 мянган төгрөгийн авлага тус тус нэмэгдсэнээс шалтгаалан 769,054.0 төгрөгөөр өссөн;
- Урьдчилгаа дансны 512,543.1 мянган төгрөгийн үлдэгдэлд тус сургуулийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 10 албан хаагчид урьдчилж олгосон нэг удаагийн тэтгэмжийн 482,351.7 мянган төгрөг, даатгалын төлбөрийн 30,191.4 мянган төгрөг тус тус бүртгэлтэй байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 4,296,001.9 мянган төгрөг болж, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,459,295.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, хандиваар ирсэн 120,500.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, 83,903.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж авсан, нийт 4,663,700.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд 4,170,319.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 282,299.7 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталсан,

44,373.3 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, нийт 496,992.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалан өмнөх оноос 166,707.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн;

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 93,390,627.7 мянган төгрөг болж, тайлант хугацаанд үнэ шинэчлэн тогтоосон 1,815,749.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 924,987.5 мянган төгрөг, бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 512,251.1 мянган төгрөг, хандив, тусламжаар ирсэн 412,282.4 мянган төгрөгийн, балансаас балансад шилжүүлэн авсан 267,267.3 мянган төгрөг, нийт 3,932,537.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталж устгасан 645,188.8 мянган төгрөг, үнэ шинэчлэн тогтоож ашиглалтын хугацааг сунгасан 4,340,253.4 мянган төгрөг, дуусаагүй барилга, байгууламж дансанд шилжүүлсэн 467,877.9 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдлийн зардал болон элэгдлийн зардлын дансны хасалтын зөрүү (596,848.7) мянган төгрөг, нийт 4,856,471.4 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалан өмнөх оноос 923,933.6 мянган төгрөгөөр буурсан;

Сургуулийн хэмжээнд нийт 480,202.5 мянган төгрөгийн 13 программ, хангамж бүртгэлтэй байна. Үүнээс Абле системийн нэгдсэн удирдлагын системийг 2022 онд авч, тус системд хувцасны хангалтын цэсийг нэмж, хөгжүүлэн ашиглаж эхэлснээр хувцас хангалтын программыг ашиглахгүй болсон байна. Тус программыг анх 2019 онд 7.7 сая төгрөгөөр худалдан авч, ашиглаж байсан ба 2024 онд ашиглах хугацаа дуусгавар болсон тул ашиглалтын хугацааг сунган, үнийг шинэчлэн 3.850.000 төгрөгөөр тогтоосон байна.

- Өглөг дансны үлдэгдэл 37,269.3 мянган төгрөг болж, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг сайжруулах ажлын 5,000.0 мянган төгрөгийн төлбөр, 2025-2026 оны хичээлийн жилд элсэгчдийн бүртгэлийн хураамжаас худалдан авалт хийхээр хуулийн этгээдтэй байгуулсан гэрээт ажлын 13,600.6 мянган төгрөгийн урьдчилгаа, ГХУСАЗЗАА-тай байгуулсан гэрээт ажлын 15,000.0 мянган төгрөгийн төлбөр, нийт 33,600.6 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлснээс шалтгаалан өглөг үүсэж, өмнөх оноос 33,600.6 мянган төгрөгөөр өссөн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 98,952,308.5 мянган төгрөг болж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралттай холбоотойгоор өмнөх оноос 163,993.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 51,841,657.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 1,531,650.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж, нийт зарлагыг 53,373,307.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нормативд зардлыг 3,897,967.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 2,170,299.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,197,134.0 мянган төгрөгөөр, цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,168,227.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 717,759.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 523,415.9 мянган төгрөгөөр, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 484,881.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 351,692.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 269,905.1 мянган төгрөгөөр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20,377.3 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 42,713,384.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь улсын төсвийн орлого бүрдээгүй, төсвийн хэмнэлтийн бодлогыг баримтлан урсгал төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх эрх зүй нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа шинжилгээ /70713/ хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 41,481,734.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 1,231,650.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 40,752,642.7 мянган төгрөг буюу 95.4 хувь байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
70713	Эрх зүй нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа шинжилгээ	42,713,384.6	40,752,642.2	1,960,741.9	95.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	35,141,891.5	33,819,010.2	1,322,881.3	95.9
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	21,740.0	20,962.6	777.4	96.4
80220	Холбооны суваг ашигласны хөлс	6,159.2	5,592.2	567.0	90.8
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	45,064.8	44,984.1	80.7	99.8
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,004,509.2	3,368,073.6	636,435.5	84.1
81822	Гадаад суралцагсдын зардал	14,373.2	14,373.2	0.0	100.0
82308	Зэвсэгт хүчний сургалт	3,479,646.7	3,479,646.7	0.0	100.0

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Дотоод хэргийн их сургууль нь боловсролын байгууллага тул Засгийн газраас хэрэгжүүлсэн 9 хувийн цомхотголд хамаарахгүй.
- Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Б/511 дугаар тушаалаар ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөгөөр тогтоож баталсан.
- Их сургуулийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг бэхжүүлэх хүрээнд БНХАУ-д 10, ОХУ-д 4, БНСВУ-д 6, БНТУ-д 3, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсад 1, Бүгд Найрамдах Индонези Улсад 1 албан хаагч, 2 сонсогчийг тус тус албан томилолтоор ажиллуулж, зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 109,407.9 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 17,725.4 мянган төгрөгийг зарцуулжээ.
- Тайлант хугацаанд төрийн албанд анх томилогдсон албан хаагч, ажилтны чиглүүлэх сургалтыг 10 чиглэлээр, албан хаагч, ажилтны мэргэшүүлэх сургалтыг 15 чиглэлээр, удирдах албан тушаалтны сургалтыг 14 чиглэлээр, хувь хүний хөгжлийн сургалтыг 10 чиглэлээр тус тус зохион байгуулж, сургуулийн хэмжээний 8, улсын хэмжээний 11, салбарын хэмжээний 12 эрдэм шинжилгээний хурал, 10 хэлэлцүүлгийг зохион байгуулж, баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 181,317.6 мянган төгрөгийг холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн зарцуулсан.
- Тайлант онд төрд учирсан хохиролтой холбоотой зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ, хэлцэл хийгээгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дотоод хэргийн их сургуулийн нэмэлт санхүүжилтийн 100900012455 тоот дансанд Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс 33,200.0 мянган төгрөг, Хил хамгаалах ерөнхий газраас гэрээт хилчдийн хоолны төлбөрт 30,860.4 мянган төгрөг, ГХУСАЗЗАА-наас Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, орчуулгын төлбөрт 16,000.0 мянган төгрөг, Гэмт хэргийн цагаан номны эмхэтгэл боловсруулах ажлын төлбөрт 18,000.0 мянган төгрөг, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг сайжруулах ажлын төлбөрт 5,000.0 мянган төгрөг, элсэлтийн хураамжийн 13,600.6 мянган төгрөг, нийт 116,661.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 98,060.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 18,600.6 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд тайлант онд нийт 3,989,209.2 мянган төгрөгийн 9 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2, харьцуулалтын аргаар 3, ерөнхий гэрээгээр 2, нууцтай холбоотой худалдан авах ажиллагаа 2-ыг тус тус зохион байгуулахаар тусгасан байна.

Тайлант онд ХЗДХС-ын 2025 оны А/105 дугаар тушаалаар “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд 91,500.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл, 88,500.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 180,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар нэмж батлуулан худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Дотоод хэргийн их сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитор Ж.Мөнхтуул гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/126 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 35,286,269.4 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 352,862.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 11,208,555.5 мянган төгрөгөөр өссөн тул материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт 46,494,824.9 мянган төгрөгийн зардлын 1 хувь буюу 464,948.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан албан хаагчдад урамшуулал давхардуулан олгосон асуудалд албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 149,391.8 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 56,149.4 мянган төгрөгийн 5 зөвлөмж, 843.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн байна.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 03 сарын 26-ны өдрийн 01/468 дугаар албан бичгээр, хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 01/1074 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	843.0	5	843.0	100.0
Зөвлөмж	5	56,149.4	8	56,149.4	100.0
Нийт дүн	7	56,992.4	13	56,992.4	100.0

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн нотлох баримтад тулгуурлан үнэлэхэд 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасан 2026-2028 онд хэрэгжих 21,343,186.7 мянган төгрөгийн төсөв өртөгтэй Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилгын 5,442,550.0 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг шалгах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг дагаж мөрдөхөд хүндрэл, бэрхшээлтэй асуудал байгаа эсэхийг судалж, хэрхэн шийдвэрлэх тал дээр санал өгөх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 406,968.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 389,243.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 17,725.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 406,968.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 57,979.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Цалин, урамшуулалтай холбоотой

Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/561 дүгээр тушаалаар 462 албан хаагчид нийт 389,243.0 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн нийт албан хаагчдад урамшуулал давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, багцалж тендер зарлах боломжтой нийт 149,391.8 мянган төгрөгийн бичгийн хэрэгслийг нэр бүхий 9 аж ахуйн нэгж, байгууллагаас шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Шууд худалдан авалт хийх зорилгоор батлагдсан төсвийг хувааж, босго үнээс доогуур төлөвлөж, шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Төсвийн зарцуулалт, тайлагналтай холбоотой

Тайлант онд дотоод томилолтын төсөвт батлагдсан 17,725.4 мянган төгрөгийг гадаад томилолтод зарцуулж, санхүүгийн тайланд дотоод томилолтын зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланд холбогдох, хууль, журамд заасан дансны ангиллын дагуу үнэн зөв тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сургуулийн захирлын 2025.12.26-ны өдрийн Б/561 дүгээр тушаалаар нийт 462 албан хаагч нарт нийт 389,243.0 мянган төгрөгийн урамшууллыг, улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулж хавтгайруулан олгосон байна.	1	389,243.0			1	389,243.0						
2	Тайлант онд дотоод томилолтын төсөвт батлагдсан 17,725.4 мянган төгрөгийг гадаад томилолтод зарцуулж, санхүүгийн тайланд дотоод томилолтын зардлаар тайлагнасан байна.	1	17,725.4					1	17,725.4				
Дүн		2	406,968.4			1	389,243.0	1	17,725.4				

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, багцалж тендер зарлах боломжтой нийт 149,391.8 мянган төгрөгийн бичгийн хэрэгслийг 9 аж ахуй нэгж, байгууллагаас шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.	1	149,391.8			1	149,391.8		
Дүн		1	149,391.8			1	149,391.8		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 101/АД/170022
САГ-2026/77/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, багцалж тендер зарлах боломжтой нийт 149,391,800.00 /Нэг зуун дөчин есөн сая гурван зуун ерэн нэгэн мянга найман зуун/ төгрөгийн бичгийн хэрэгслийг нэр бүхий 9 аж ахуйн нэгж, байгууллагаас шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд худалдан авалт хийх зорилгоор батлагдсан төсвийг хувааж, босго үнээс доогуур төлөвлөж, шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод хэргийн их сургуулийн захирал, Бригадын генерал (Т.Сүхболд), Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Т.Гантулга) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР


9006109
ATA1608

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-12.Docx

1526180274



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 102/АД170022
САГ-2026/77/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Б/561 дүгээр тушаалаар 462 албан хаагчид нийт 389,243,000.00 /Гурван зуун наян есөн сая хоёр зуун дөчин гурван мянган/ төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сургуулийн нийт албан хаагчдад урамшуулал давхардуулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод хэргийн их сургуулийн захирал, Бригадын генерал (Т.Сүхболд), Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Т.Гантулга) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Ж.МӨНХТУУЛ